

БИЕИЙН ТАМИРЫН БАГШ НАРТ ЗӨВЛӨМЖЛӨХ НЬ

Дэлхийн улс орны хотжилт, техник технологийн хөгжилтэй холбоотойгоор суурин иргэншил давамгайлах болж, хүн амын амьдарлын хэв маяг өөрчлөгдөн улс орнууд биеийн тамир, спортыг дэмжих замаар хүнийг хөгжүүлэхэд анхаарлаа хандуулаад байна.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хөдөлгөөний хэрэгцээг хангах, оюуны хөдөлмөрийн алжаалыг тайлах, бие бялдрын өсөлт хөгжилтийг зохих түвшинд хүргэхэд нөлөөлөх дасгал, хөдөлгөөнөөр системтэй хичээллүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлагатай болж байна.

Биеийн тамирын боловсролын стандартын хэрэгжүүлэх үндсэн асуудал нь

- Хөдөлгөөний дутагдлаас сэргийлж, оюуны болоод бие бялдрын чадвартай иргэдийг бэлтгэн, улс орны тогтвортой хөгжлийг хангах нь НИЙГМИЙН ЭРЭЛТ,
- Насан туршдаа тасралтгүй суралцаж, бүтээлчээр ажиллаж, чанартай амьдрахад зайлшгүй шаардлагатай, бие бялдрын хөгжил, биеийн тамирын боловсрол олж авах нь ХУВЬ ХҮНИЙ хэрэгцээ юм.

Энэхүү зөвлөмжийн зорилго нь БСШУСЯ-аас хэрэгжүүлж буй цөм хөтөлбөрийн хүрээнд Биеийн тамирын боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах үзэл баримтлалд нийцүүлэн дасгал техникийг сургахын зэрэгцээ бие бялдрын чанаруудыг хөгжүүлэхдээ тухайн орон нутаг, сургуулийн материаллаг бааз орчинтойгоо уялдуулан бодитой тодорхойлох нь маш үр дүнтэй юм.

АГУУЛГА, АРГА ЗҮЙН ТАЛААР АНХААРАХ НЬ:

- БСШУСЯ-ны 2018 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн А/453 тоот тушаал “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” тушаалд 1-анги-56 цаг, 2-р анги-64, 3-5-р анги-66цаг, 6-12-р анги-70 цагаар сургалтын хөтөлбөрийг төлөвлөх
- Багш бүр хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулахдаа хамтарч багаар боловсруулах нь биеийн тамирын хичээлийн үндсэн асуудал болох энгийнээс төвөгтэй, хөнгөнөөс хүндрэх зарчмаар анги болгоны агуулга өргөжин гүнзгийрэх нь сургуулийн нэгдсэн хөтөлбөр төлөвлөгөө бодитой болох учир анхаарлаа хандуулаарай.
- Биеийн тамирын сургалтын хөтөлбөрийн агуулгын хүрээнээс хичээлийн агуулгаа сонгохдоо хүүхдийн нас бие бялдрын онцлогт тохируулан оновчтой сонгох
- Нэгж хичээлийн тогтолцоог боловсронгуй болгох, анги бүрийн нэгж хичээлийг хамтарч системтэй тодорхойлох, нэгж хичээлээр эзэмших мэдлэг, чадварыг тодорхой болгож, үнэлгээний даалгавар, шалгуур, аргачлалыг боловсруулах
- Ээлжит хичээл дээр сурагч ямар үйл хийснээс хамааран сурагчдын эзэмших мэдлэг чадвар шалтгаалдаг бөгөөд багш та тухайн ээлжит хичээлийг үр бүтээлтэй зохион байгуулан явуулахад машинд анхаарах нь зүйтэй.
- Спортын секц дугуйлангийн төлөвлөлтийг боловсруулахад жил, сар, 7 хоног, 1 өдрийн циклийг тодорхойлж дасгал техник, ачаалал, амралт сэргэлтийг хэдэн цагийн бэлтгэл авах ямар үр дүнд хүрэхийг тодорхойлох
- Багш бүр өөрийн хариуцан орж буй ангийн сурагчдын бие бялдрын түвшин тогтоох сорилыг авч нэгтгэн тухайн сургуулийн сурагчдын биеийн чанарын үзүүлэлтийг графикаар гаргаж дүгнэлт хийх

- Биеийн тамирын бүх багш нар судалгаагаа нэгтгэж, тухайн сургуулийн бүх сурагчдын биеийн таван чанарын үзүүлэлтийг нас насны ангиллаар нь гаргасан судалгаатай болох
- Биеийн ямар чанар дутагдалтай байгааг илрүүлж түүнд тохирсон дасгалын нөөцийг бий болгож, нас насанд нь тохирсон дасгалыг ээлжит хичээл болгоны өмнө хийлгүүлж байх
- Биеийн тамирын хичээлд ордоггүй жингийн илүүдэлтэй, төрөлхийн болон гэмтлийн гаралтай сурагчдын нэгдсэн судалгааг гаргаж тухайн дүүргийн эрүүл мэндийн төвтэй хамтран өвчний оношид нь таарсан дасгал хөдөлгөөнийг бие даалт болон нэмэлт байдлаар хийлгүүлж хэвшүүлэх хэрэгтэй байна.

СУРГАЛТЫН ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ ТАЛААР:

- ✚ БШУЯ-ны Сайдын 1996 оны 253 тоот тушаал “Кабинетын ерөнхий заавар батлах тухай”, Нийслэлийн Боловсролын газрын даргын 2015 оны 03 сарын 27 өдрийн А/24 “ЕБС,Цэцэрлэгийн сургалтын орчин бүрдүүлэх заавар”-ын дагуу өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан засаж сайжруулах, сургалтын таатай орчин бүрдүүлэх, стандартад нийцүүлэх талаар анхаарлаа хандуулж санал санаачилгатай ажиллах нь зүйтэй .

ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХАД БАРИМТЛАХ ЭРХ ЗҮЙ

Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Сайдын 2018 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн А/453 ооот тушаал “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай”

Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Сайдын 2018 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн А/551 тоот тушаал “Сургалтын хөтөлбөр шинэчлэн батлах тухай”

Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Сайдын 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн А/425 тоот тушаал “Журам шинэчлэн батлах тухай”

ХҮҮХДИЙН БИЕ БЯЛДАР, СПОРТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН А.ГАНТУЛГА